

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
МОНГОЛ ХЭЛ СОЁЛЫН СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

XXXVII (392)

2013

(213-221)

ЭХ ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ЭРХЭМ ЗОРИЛГО

Ч. Баттулга *

Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд “эх хэл”¹-ний сургалтад тодорхой ахиц дэвшил гарсан нь дамжиггүй ч стандартын хэрэгжилт хангалтгүй буюу сурагчид монгол хэлний хичээлээр зөв сайхан ярьж, бичих чадварыг бүрэн дүүрэн эзэмшиж чадахгүй байна.

Монгол хэлний хичээлээр сурагчид ярих бичих чадвар бүрэн дүүрэн эзэмшиж чадахгүй байгаа тухай асуудал зөвхөн одоо ярьж байгаа зүйл биш ажээ. Тухайлбал:

Эрдэмтэн Б.Бямбасүрэн “ЕБС-д зааж байгаа хэлбичгийн хичээлийн агуулгыг улам боловсронгуй болгох асуудал нэн чухал шаардагдаж байна. Гэтэл сургалтын агуулгад байгаа үндсэн дутагдал гэвэл дунд сургуульд “Хэлбичиг” гэдэг нэрээр судалж байгаа

* МУИС, Монгол хэл, соёлын сургууль, Монгол хэлний тэнхим

¹) Эх хэл гэдэг бол юу гэсэн утгатай нэр вэ? гэвэл, тухайлсан үндэстэн улсын хүн бүр хоорондоо харилцахдаа хэрэглэдэг хэл нь эх хэл болно. Монгол хүнд монгол хэл нь даруй эх хэл, орос хүнд эх хэл нь орос хэл, англи хүнд англи хэл нь эх хэл болно. Бусад үндэстэн улсын хэл нь даруй харь хэл болно. Манай монголоор эх нутаг, эх түүх, эх орон, эх хэл гэж эх гэдэг үгтэй холбон нэрлэдэг эл нарийн зүйлд эх гэсэн үг нь өөрийн бөгөөд эх мэт **дотно** болсон, эх мэт **хайрлан энхрийлэх** гэсэн санаа бүхий нэр болно. Орос хэлнээ манай эх хэл гэдгийг орос хэлний сэтгэхүйн үүднээс “родной язык” гэдэг нь “родной” гэсэн үгийн утга нь “род” гэсэн үндсэн үгнээс үүдсэн бөгөөд тэр “род” гэдгээс орос хэлнээ өдий төдий үг нэр үүдсэн нь: на+род гэж ард түмэн, род+и+на гэж эх орон по+род+а гэж үүлдэр, при+род+а гэж байгаль, у+род гэж муухай, гаж буруу төрхтэй амьтан у+роже+ай гэж “д” нь “ж” болон сэлгэж ургац гэх зэргийн маш олон үг ганц “род” гэсэн үүдэх, төрөх гэсэн утга бүхий үндсэн үгнээс гарч монгол зэргийн бусад хэлнээ орчуулбал эл нэгэн үндсэн үгнээс утвар залган олон үг бүтсэн нь, өөр соёл, өөр сэтгэхүйтэй улсын хэлнээ хоорондоо хавьдахгүй юмыг нэгэн үндсэн үгнээс үүдсэн бүтээсэн байнам.

Манай орчуулагчид нарийн учры нь мэдээгүйн улмаас, родная страна гэдгийг **төрөлх орон, родной язык гэдгийг төрөлх хэл** гэж ташааран орчуулдаг нь тэр оронд төрөөгүй, өөр гадаадад төрсөн хүн ч өөрийнхөө орныг эх орон, эх нутаг гэсэн утгаар хэрэглэж байгаа үг болохоос, заавал төрсөн газар гэсэн санаа биш, төрөлх хэл гэж орчуулахдаа, хүн төрөхдөө ерөөс хэлтэй төрдөггүй, хэзээ хойно хэлэнд ордог байгалийн ёс жамыг бодолгүй, хүнийг **төрөхдөө хэлтэй** үгтэй гэж байгалийн байдал, шинжлэх ухааны ёсонд огт таарахгүй буруу гажуугаар орчуулсан улмаас түүний утгы нь эргэцүүлэн бодохгүй муу орчуулгыг дууриан дагахад хүрдэг гэм байна. Иймд найруулгазүйн ёсонд “төрөлх хэл” гэдэг буруу ташаа орчуулгын гаж буруу хэллэгийг засан, “эх хэл” гэж “родной город” гэдгийг утга учры нь ухаараагүй орчуулагчийн ам дагаж уг санаа нь “энхрий хот” гэж хайртай дотнын санаанаас нэрлэсэн утгатай нэрийг “төрсөн хот” болгож тэр хотод огт төрөөгүй хүнийг “төрсөн” болгодог буруу орчуулсан гажууг засан залруулж монгол хэлнээ элэгсэг **дотно, энхрий хайртайг “төрөлх” гэдэг ёс байхгүй, байгаа ч үгүйг бодож “родной” гэдгийг ганцхан “төрөх” гэдгээр ухааран орчуулсан үг дагаж найруулсан үгийг, чухам төрөхийг хэлсэн байна уу, дотно элэгсгийг хэлсэн байна уу, төрөл садан гэсэн санаа байна уу? гэж утгы нь бодож хянан эргэцүүлж байхыг захиуштай байна. Б.Ренчин, Найруулга зүйн товчоо, Сурган хүмүүжүүлэгч, 1971№3, 89-90 тал**

хэлшинжлэлийн арваад салбар ухааны, анги хоорондын уялдаа зохицол, хэмжээ, сургалтын систем нь “утга зохиолын хэлэнд сургах” гол зорилтыг биелүүлэх нөхцөл бололцоог хангахуйц хэмжээнд хараахан бүрэн боловсорч чадаагүй байгаа... Иймээс ч ЕБС-ийн хэлбичгийн хичээлийн сургалтын агуулгыг цаашид боловсруулахдаа энэ үзэл санаанд захируулан хэлийг зөв хэрэглэхэд тусалдаг хэлзүй, зөв бичих, дуудах зүй хэлийг сайн хэрэглэхэд тусалдаг үгийн сан, найруулга зүйн дэвсгэр мэдлэгийг олгох сургалтын холбоог зөв тогтоох нарийн бөгөөд чухал асуудал тавигдаж, хэлбичгийн хичээл нэгбүрийг заах тухай бид ярилцахдаа юуны урьд энэ хичээлээр олгож буй шинэ мэдлэг, дасгал, бичгийн ажлаар сурагчдын хэлийг зөв эзэмших ямар хэрэгцээг хангаж байна вэ гэдгийг байнга тооцож, зөв сайхан бичиж, найруулж сурах хэрэгцээг хангахад чиглүүлж байх буюу хичээл бүрийг зөв сайн бичиж нарийуулах үндсэн чигийг баримталж явуулах хэрэгтэй юм² гэсэн маш чухал санал дэвшүүлж байжээ. Мөн тэрээр “Нийгмийн идэвхтэй нөхцөлд амьдарч сурч байгаа манай сурагчдын хичээл сургалтын ажил идэвхтэй байх шаардлагатай. Энэ шаардлагыг хангаагүй хичээл дээр сурагчид “ажилгүй” сууж улмаар сахилгагүйтэх, сонирхолтой өөр зүйлд идэвх хүчээ зарцуулж өөр юм хийж, эцсийн эцэст бидний зааж байгаа хэлбичгийн хичээлд сонирхолгүй, идэвхгүй болох тал байна. Гадаад “идэвхтэй” мэт байдлыг “Томоотой суу”, “Анхааралтай бай” гэх мэт захиргааны аргаар бий болгож болох авч сургалтын үйл ажиллагааны гол зүйл болох сэтгэхүйн идэвхтэй, дотоод чанарыг бий болгоход хамгийн гол нь сурагчдыг сэтгэхүйн бие даасан ажилд татан оролцуулж хамтран ажиллах явдал мөн”³ гэжээ.

Эрдэмтэн Д.Отгонсүрэн “Бичиж найруулж сурна гэдэг нь дүрмийн мэдлэг төдий биш, бас материаллаг хэрэглээ юм. Үлгэрлэвэл, физик судалснаар ойр зуурын техник хэрэгслээ өөрөө засч сэлбэж, хими судалснаар элдэв бодисын ашиг хорын ялган арчиж цэвэрлэхээс аж амьдралдаа хэрэглэж байдаг нь тэр ухааныг судалсан онолын мэдлэгээ материаллаг хэрэгцээнд ашиглаж буй хэрэг бөгөөд монгол хэлний хичээлийн хувьд энэ нь юу байж таарах вэ? гэвэл өвөг дээдсийнхээ өв их соёл, монгол хэлээ судалж, эх хэлнийхээ яруу тунгалаг найруулгын хэв горим, ёс уламжлалын дагуу ойлгомжтой сайхан найруулж сурах явдал юм⁴ гээд оюутан сурагчдын бичгийн ажилд тулгуурлан дараах дүгнэлтийг гаргажээ. Үүнд:

- 1) Бүрэн дунд боловсролтын бичгийн соёл дулимагхан байна... Хичээл заадаг багш нар энэ талаар санаа тавихгүй бол монгол хэлний хичээлийг арван жил үзсэн бүрэн дунд боловсролтон нарын маань бичгийн соёл, өөрийн оролдлогоор бичиг сурч захиа бичихтэй болсон хүний бичгээс ялгарахгүйд хүрэх нь байна.
- 2) Найруулах чадвар муу байна. Илүүц үг давтаж нурших, хэдхэн үгийн дотор эргэлдэх, үгийг сонгохдоо ямар нөхцөлд юуны тухай бичихээ бодохгүй зэрэг. Хичээл зааж байгаа багш нар жишээ авсан өгүүлбэрээ найруулгын хувьд бодож нягталж, өгүүлбэр зохиолгохдоо дүрмийг анхаарахын зэрэгцээ найруулгыг сайн анхаарч доголдол дутагдлыг дор бүр нь хэлж өгч байвал найруулгын аар саар алдаа гарахгүй байж болох юм.

²⁾ Б.Бямбасүрэн, Хэлбичгийн хичээлд сурагчдыг сонирхолтой болгох асуудалд, Сурган хүмүүжүүлэгч, 1978, №1, 53-55-р тал

³⁾ Мөн тэнд, 55-56-р тал

⁴⁾ Д.Отгонсүрэн, Бүрэн дунд боловсролтын бичиж найруулах чадварын тухайд, Сурган хүмүүжүүлэгч, 1972 №2, 33-р тал

- 3) Найруулан бичих зохион бичих болон аливаа юмс үзэгдлийн тухай бичихдээ төлөвлөж дэс дараа гаргаж чадахгүй тал байна. Арван жилийн сургуульд байхдаа төлөвлөгөө гаргаж сурахгүй бол хэзээ сурах билээ.
- 4) Бичиж байгаа зүйлээ хянаж засч сураагүй байна. Бодол санаагаа хүнд зөв дамжуулахын тулд бодож бичиж байгаагаа цэгнэж нягталж сураагүйгээс найруулгын ноцтой алдаа гаргасан хэрнээ засч чадахгүй, зөв бичгийн дүрмийн алдаагаа харахгүй байна. Бүрэн дунд боловсролтын бичих найруулах чадварыг зөвхөн энэ бичгийн ажлаар хангалттай дүгнэж чадахгүй нь мэдээж.

Эрдэмтэн Г.Эрдэнэ-Очир “Монгол хэлний хичээлийн сургалтын үр дүнг дээшлүүлье” гэсэн өгүүлэлдээ:

1. Хэл бичгийн хичээлээр сурагчдыг хэлэнд (язык) сургаад хэл ярианд (речь) сургаж чадахгүй байна.
2. Мэдлэгийг нь чадвар дадал болгож чадахгүй байна⁵ хэмээн нилээд судалгаа, үндэслэлтэй дүгнэлт гаргасан байдаг.

Түүний зарим судлагаанаас дурдвал: ... Бага ангийн 381 сурагчийн 38 хувь нь, дунд ангийн 388 сурагчийн 44,5 хувь нь ахлах ангийн 324 сурагчийн 20 хувь нь тус тус монгол хэлний хичээл хүнд байна гэжээ. Эндээс зөв бичгийн дүрмийн үндсэн мэдлэг чадвар дадал олж авахад бага, дунд ангиудад монгол хэлний хичээл хүндэд тооцогдож байгааг олж харахад түвэггүй байна. 4-7 ангийн 388 сурагчаас монгол хэлний хичээлийн чухам юун хэцүү байна вэ? гэх асуултаар хариу авахад 47 хувь нь зөв бичгийн дүрэм ойлгож тогтоох ба цээж бичгийг алдаагүй хийх нь хүнд байна гэж хариулсан байна. Бас эдгээр сурагчдын 42,9 хувь нь дүрмээ мэддэг боловч алддаг гэсэн байхад, 12,2 хувь нь зөв бичгийн дүрэм мэддэггүй хэрнээ төдий л их алддаггүй гэжээ. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцсон бүх сурагчдын 55,3 хувь нь зөв бичгийн дүрмийн мэдлэг, алдаагүй бичих бичих чадвар дадал хоёрын зохистой холбоогүй гэдгээ хүлээн зөвшөөрч байна. Иймээс монгол хэлний хичээлийн сургалтын үр дүнг дээшлүүлэх нэг үндсэн асуудал нь сурагчдад зөв бичгийн дүрмийн мэдлэг чадвар дадлыг олгож хэвшүүлэх явдал юм⁶ гэсэн байна.

Эрдэмтэн Л.Түдэв “Таваас долдугаар ангид ангид үзэх сурах бичигт онцгой анхаарах учиртай бөгөөд тэр насны хүүхдүүдийн онцлог нь үүнийг шаарддаг юм. Гэтэл үүнийг харгалзсан сурах бичиг уран зохиол мэтийн хамгийн сонирхолтой байж болох чиглэлээр ч бас л учир дутагдалтай байсаар ирлээ. Дунд сургуулийн долдугаар ангид үзэх “Уран зохиол” (1975) сурах бичиг гэхэд өөрийн орны 12 зохиолч, оросын 5, польшийн нэг, туркийн нэг зохиолчийн бүтээл оржээ. Өөрийн орны зохиолчдыг дийлэнх болгон авсан нь сайшаалтай боловч “Орос, зөвлөлтийн ба дэлхийн сонгодог уран зохиолоос” гэсэн бүлэгтээ агуулга нь зохилдоогүйг “дэлхийн сонгодог” гэдгийн дор ердөө Э.Войнич (АНУ-д цагаачлан сууж байсан польш авгай), Н. Хикмет (Орост цагаачлан сууж байсан түрэг шүлэгч) хоёроор төлөөлүүлсэн мэт оруулсан нь хэтэрхий өрөөсгөл ойлголт хүүхдэд өгөхөөр болсон ажээ. Өнөөх Франц, Герман, Италийн сонгодогууд, энэтхэг, хятад, японы алдартангуудаас ганц ганц нэр оруулсан бол хэлэх үг юу байхав. Гэтэл тэр цагийн өрөөсгөл хандлагын нөлөөтэй толь ийм байсан хэрэг⁷.

⁵ Г.Эрдэнэ-Очир “Монгол хэлний хичээлийн сургалтын үр дүнг дээшлүүлье”, Сурган хүмүүжүүлэгч, 1972

⁶ Мөн тэнд

⁷ Л.Түдэв, Боловсроогүй боловсрол, Улаанбаатар, 1996, 28-29 тал

...Улсын багшийн дээд сургуулиас хот хөдөөгийн багш нарын дунд 1987 онд судалгаа хийхэд тэдний 27,7 хувь нь заах аргын, 40 хувь нь сурган хүмүүжүүлэх ухааны, 64,4 хувь нь сэтгэл судлалын мэдлэгээр тааруухан дүнтэй гарчээ. Сурагчийн дээр ярьсан болгоны нууц үүнд байгаа хэрэг. Гэтэл бас мөнхүү УБИС-д түүх-нийгэм судлалын багш бэлтгэхэд сургалтын хугацаанд оюутан 4500 цагийн хичээл үздэгийн 86 хувийг янз бүрийн түүх үзэхэд зориулж, үлдсэн 14-хөн хувьд нь багш болох гол хичээл сурган, сэтгэл судлал, заах арга, сургалтын техник хэрэгсэл, логик социологи үздэг байлаа. Багш нар ийм чиглэлээр тааруухан дүн авдгийн бас нэг нууц үүнд байсан бишүү⁸ гэсэн байдаг.

Харин эрдэмтэн Ц.Оюун дунд, ахлах ангийн монгол хэлний сургалтын агуулгад хэлний салбаруудын эзлэх хувийг ийнхүү тодорхойлохын сацуу:

№	Хэлний салбарууд	1937-1940	1941-1960	1961-1980	1981-1995	1996-2000	1937-2000
1.	Авиазүйн бүлэг	8,1	6.8	4.2	5.1	6.0	4.7
2.	Үгзүйн бүлэг	40.5	37.3	30.5	33	23.5	25.8
3.	Өгүүлбэрзүйн бүлэг	51.4	52.5	27.1	29.9	24.2	24.7
4.	Үгийн сангийн бүлэг			16.9	10.3	15.3	13.7
5.	Найруулгазүйн бүлэг		1.7	9.3	13.4	12.1	11.0
6.	Хэлний тухай мэдэгдэхүүн			6.8	7.2	6.7	8.4
7.	Утга судлалын холбогдолтой сэдэв				1.0	3.4	2.6
8.	Эх судлалын бүлэг					4.0	3.1
9.	Толь зүйн бүлэг		1,7	5.1		4.7	5.8

...1937 оноос эдүгээ хүртэл монгол хэлний сургалтын агуулгад хэлзүй хэтэрхий голлох байртай, тэр дотроо өгүүлбэрзүйн бүлэг дунджаараа ихэнх цагийг эзэлж байжээ. Ялангуяа 1941-1960-аад оны хөтөлбөрт өгүүлбэрзүй хэлшинжлэлийн бусад салбарыг судлах бүх цагийг нийлүүлснээс илүү буюу 52,5 хувийг эзэлж байв⁹ хэмээн хэлбичгийн хичээлээр хэлний бүтэц, хэлзүйн дүрэм заахад хэтэрхий хэлбийж байсныг нарийн судалгаагаар тогтоосон байна.

Судлаач Д.Ганболд “Монгол хэлний боловсролын түүхэнд гарсан нэг томоохон хувьсгал бол 2004 онд батлагдсан “Монгол хэл, Уран зохиолын боловсролын стандарт” юм.

- 2006-2012 онд Боловсролын үнэлгээний төвийн (БҮТ) зохион байгуулсан Элсэлтийн ерөнхий шалгалт (ЭЕШ)
- 2007-2008 онд БСШУЯ, БҮТ-ийн зохион байгуулсан “Бага боловсролын математик, унших чадварын үндэсний үнэлгээ”
- 2005 онд БСШУЯ-аас хэрэгжүүлсэн “Бага боловсролын сурлагын амжилтын үнэлгээ”
- 2012 онд БҮТ-өөс зохион байгуулсан түвшин тогтоох үнэлгээ...

⁸⁾ Мөн тэнд, 70-71 тал

⁹⁾ Ц.Оюун, Монгол хэлний дидактик, Улаанбаатар, 2000, 45 тал

Эдгээр судалгааны тайлангууд Монгол хэл, Уран зохиолын боловсролын стандартын хэрэгжилтэд хангалтгүй гэсэн үнэлгээг өгсөн байдаг. Энэ нь Монгол хэлний сургалтын тулгамдсан асуудал болоод байгаа¹⁰-г дурдаад мөн өөр хэд хэдэн шалгалтын дүнг судалгааны материал болгон ашигласан байна. Үүнд:

1. Монгол Улсын БСШУЯ-ны захиалга, Дэлхийн банкны санхүүгийн дэмжлэгтэйгээр “Хөдөөгийн боловсролыг дэмжих төсөл”-ийн хүрээнд “Бага боловсролын математик, унших чадварын үндэсний үнэлгээ”-г БҮТ-с 2007-2008 онуудад зохион байгуулсан байдаг. Энэ судалгаагаар Монгол хэл, Уран зохиолын боловсролын стандартын хэрэгжилт 48,0 хувь
2. Монгол хэл, уран зохиолын боловсролын стандартын хэрэгжилтийн түвшинг тогтоох, суралцагчдыг оноогоор эрэмбэлэх зорилгоор ЭЕШ-ыг зохион байгуулдаг бөгөөд агуулга, даалгаврын боловсруулалт, шалгуулагчдын мэдлэг, чадварыг testan болон SPSS программууд ашиглан түүний үр дүнд боловсруулалт хийн жил бүр тайлан гаргадаг байна. 2007 онд 43.5, 2009 онд 37.8, 2010 онд 46.5, 2011 онд 47.7, Хувилбар дундаж 43.9
3. 2012 онд Монгол хэл, уран зохиолын стандартын хэрэгжилтийн түвшинг тогтоох зорилгоор хөндлөнгийн үнэлгээг түүврээр зохион байгуулсан. Шалгалтад 7-р ангийн 2050 сурагч, 10-р ангийн 1677 сурагч хамрагдсан. Монгол хэл, уран зохиолын стандартын хэрэгжилтийн дундаж дүн 7-р анги 50,2(F), 10-р анги 47,9(F) үнэлгээ
7-р ангийн стандарт хэрэгжилт 41,7%, чанар 10,1%
10-р ангийн стандарт хэрэгжилт 25,9%, чанар 2,2%
10-р ангийн шалгалтад хамрагдсан суралцагчдын 59,0%,
10-р ангийн шалгалтад хамрагдсан суралцагчдын 73,0 % нь “F” үнэлгээ авчээ ¹¹ гэсэн байна.

Мөн бидний, монгол хэлний хичээлийг сурагчид хэр сонирхдог, тэдний эх хэлний үнэлэмж ямар байдгийг тодруулсан асуулга судалгааны дүн ч дээрхтэй бараг мөргөж буй юм. Ийнхүү монгол хэлний сургалтын чанар, стандартын хэрэгжилт сайнгүй байгаа нь эх хэлний сургалтын зорилгыг оновчтой, зөв тодорхойлоогүйтэй холбоотой.

Иймээс эх хэлний сургалтын зорилгыг оновчтой, зөв тодорхойлох асуудал чухал байна. Мэдээж хэрэг, ганц нэг хүн судалгаа шинжилгээ хийгээд энэ асуудлыг шийдвэрлэж чадахгүй нь ойлгомжтой ч өөрийн саналыг нэмэрлэв.

Үндэсний хэл бичиг хичээлийн зорилгыг дараах маягаар тодорхойлж иржээ. Үүнд: Уламжлалд суурилсан эх хэлний сургалт (1912-1940-өөд он)-ын үед, *“Бага дунд сургуулийн ерөнхий эрдмийн систем дотор орсон олон төрлийн хичээл дотроос үндэсний хэл бичиг нь ерөнхий бөгөөд үндэсний суурийг эзэлнэ. Улс нэг бүрийн аж байдал ба хүн хүн нэг бүрийн амьдрах зэрэг ихээхэн дадлагын чанартай түүхт байдал дээрээс үндэсний хэл бичиг сурч судлах явдал нь туйлын их гүн утга чанарыг харгалзсан байна. Хэл бол улсын хоорондын харилцаа ба соёл боловсролтой болж дэвшиж хөгжих явдалд туйлын чухал зэвсэг нь болж өгнө. Хэл бичиг сурах явдал бол бусад хичээлийн нэг адил өөрийн тайлбартай байна. Энэ нь:*

- алдаа мадаггүй уншиж сурах
- алдаа мадаггүй цэвэр бичиж сурах

¹⁰⁾ Д.Ганболд, монгол хэл, уран зохиолын стандартын хэрэгжилт түүнийг сайжруулах арга зам, илтгэлээс

¹¹⁾ Мөн илтгэлээс

- сурагчдын үгийг баяжуулах
- сурагчдыг алдаагүй бичүүлэх, уншуулах

хийгээд тэдгээрийн үгийг боловсон баялаг болгох явдал нь үндэсний хэл бичгийг заах багш, ажил дээрээ хэрэглэвэл үндсэн зорилго нь болно. Хэл бичгийн сурлагыг дээшлүүлэх ба сурагчдын үгийг боловсролоор баяжуулан бүх сургуулийн хичээл сурлага болон сурган хүмүүжүүлэх ажилд их хөгжилтийг үзүүлнэ. Иймээс сурагчдыг уншиж бичих болон үгийн баялгаар ядуулаг байвал сургуулийн бүх хичээлийн амжилтанд үндсэн саад тээг болно¹².

Шинжлэх ухаан, соёл, гэгээрлийн үеийн эх хэлний сургалт (1941-1989 он)-ын үед, 1961 онд: *Үндэснийхээ хэл бичгийг нарийн судлан эзэмшихэд юуны өмнө төрөлх хэлний зүй тогтол, авиан зүй, үг зүйн онцлог, үгүүлбэрийн нарийн тогтолцоог гүнзгий судлан ойлгох явдал эрхэм чухал. Сурагчид төрөлх хэлнийхээ өвөрмөц онцлогтой танилцсанаар өөрийн төрөлх хэлэнд дуртай, хайртай, түүний үндсэн мэдлэгийг эзэмшихийн төлөө цуцалтгүй тэмцэж, ажилч хичээнгүй, эх оронч хүн болон хүмүүждэг байна.*¹³

1976 онд: *Дунд сургуульд хэлбичгийн хичээлийг заахдаа эх орондоо социализмыг гардан байгуулагч залуучуудын нийгмийн олон талт үйл ажиллагаанд идэвхтэй оролцоход нь зайлшгүй шаардагдах ярианы ба бичгийн хэлийг хэрэглэн зарж чадах чадалтай болгох зорилт тавив.*¹⁴

1985 онд: *Энэ хичээлээр сурагчид эх хэлний боловсрол олж, утга зохиолын хэлний хэм хэмжээг мэдэн яриа бичгийн соёл эзэмидэг нь бусад бүх хичээлд амжилттай суралцахын дэвсгэр болдгоор барахгүй, улмаар хүрээлэн байгаа үнэн бодит байдлын тухай мэдлэгээ байнга өргөтгөн гүнзгийрүүлж мэдлэг боловсрол эзэмшихийн үүдийг нээх түлхүүр болж өгнө. Түүнчлэн хүүхдийн хүмүүжүүлэх өргөн дэлгэр бололцоо энэ хичээлд бий.*¹⁵

Онол, хэрэглээ хосолсон эх хэлний сургалт (1990 оноос -2013)-ын үед:

*Монгол хэлний боловсролын зорилго нь нийгэм ахуйн янз бүрийн орчинд аман ба бичгийн хэлээр соёлтой, ухаалаг харилцах мэдлэг, чадвартай, эх хэлнийхээ баялаг сайхныг амтлан бахархах төдийгүй түүнийг хөгжүүлэх цогц чадамж бүхий иргэн төлөвшүүлэхэд оришино. Түүнчлэн, суралцагчад эх хэлнийхээ үгийн санг баялаг оновчтой сонгон зөв хэрэглэх чадвар эзэмшүүлж, түүний баялаг, сайхныг мэдэрч, эх хэлээрээ бахархах, түүнийг хамгаалах, хөгжүүлэх хандлага төлөвшүүлэхэд тус болох явдал юм.*¹⁶

Эрдэмтэн судлаачид боловсрол хэмээх ойлголтыг олон талаас нь янз бүрээр тодорхойлдог боловч “Боловсрол хүмүүсийн зан төлөвийг өөрчлөх үйл явц”¹⁷, “Боловсрол бол иргэнийг төлөвшүүлэх үүрэг бүхий нийгмийн үзэгдэл, үнэт зүйл,

¹²⁾ МУУТА. Ф-6. Д-2. Хн-298. Хуудас117

¹³⁾ Т.Гомбосүрэн, Төрөлх хэл бичгийн хичээлийн заалтын чанарыг сайжруулъя, Сурган хүмүүжүүлэгч, 1961 №1, 22-р тал

¹⁴⁾ Ерөнхий боловсрол, хөдөлмөр политехникийн дунд сургуульдүзэх хичээлийн программ (монгол хэл, уран зохиол IV-X), Улаанбаатар, 1976, 3-р тал

¹⁵⁾ Ерөнхий боловсрол, хөдөлмөр политехникийн дунд сургуульдүзэх хичээлийн программ, (монгол хэл, уран зохиол), Улаанбаатар, 1985, 3-р тал

¹⁶⁾ Монгол хэл уран зохиолын боловсролын стандарт, Улаанбаатар, 2003, 12-р тал

¹⁷⁾ Н.Наранчимэг, Э.Төгөлдөр, Боловсролын удирдлага, Улаанбаатар, 2010, 249 тал

нийгэм оршин тогтнох, цааш хөгжин дэвших гол үндэс суурь”¹⁸ гэсэн тодорхойлолт гол байр суурийг эзэлдэг.

Харин сургалтын зорилго нь нийгмийн болон суралцагчдын хэрэгцээ сонирхлоор тодорхойлогдоно. Уламжлалт хандлагаар нийгмийн хэрэгцээ, шаардлагыг түлхүү анхаарч сургалтын зорилгыг тодорхойлдог байв. Орчин үед сургалтын зорилгыг тодорхойлохдоо суралцагчдын хэрэгцээг оновчтой харгалзах, тэдний оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч тэднийг идэвхтэй оролцуулах оролдлого хийж байна. Сургалтын зорилгоо тодорхойлохдоо суралцагчдын эзэмшвэл зохих мэдлэг, чадварт түлхүү анхаарч ирсэн. Өөрөөр хэлбэл, мэдлэг эзэмших тал руу ихээхэн анхаараад суралцагчдын төлөвшил, хөгжлийн асуудалд бага анхаарч иржээ. Олон жилийн турш боловсролын салбарт ноёрхсон энэхүү хандлагын үр дагавар нь өнөө үеийн монголчууд бидний ёс суртахууны дүр зурагт тодорхой утгаар нөлөөлсөн гэж үзэх хандлага байдаг¹⁹.

ШУ-ны тодорхой ойлголтыг жишээ дасгалаар өгөх нь зүйн хэрэг боловч, бие хүнийг төлөвшүүлж байгаа гэдгээ бид мартаж учиргүй. Иймээс хүүхэд багачууддаа сургаж ч, хүмүүжүүлж ч чаддаг байсан монгол ардын уламжлалт аргаас тодорхой системтэйгээр суралцуулах нь өнөөдрийн сургуулиудын хойшлуулалгүй зорилго болж байна.²⁰

Сургалт нэг загвараас гарахгүй байна, үзэж байгаа хичээлийн тоо олон, бүх хүүхдийг заавал сургуульд хамрах гэхийн шаардлагагүй, сонгон сурах бололцоо алга, зааж буй зүйл амьдрал, хөдөлмөрөөс хол байна, сургалт, хүмүүжил саланги байна, сургууль, багш нар хүчин чармайлтаа сайн гаргахгүй байна, сурагчдын бие даасан идэвх, бодож сэтгэх чадвар хангалтгүй байна гэх мэтээр хэвлэл мэдээлэлд ч их нийтэлж, нэвтрүүлж байна. Хурал цуглаан дээр ч тасралтгүй ярьж байна. Энэ бол олон жилийн эцэс төгсгөлгүй яриа, шүүмжлэлийн үргэлжлэл юм. Үүний гол шалтгаан нь сургалтын нийт системд нэг арга хэлбэр, тухайлбал, хийсвэр арга зонхилж ирсэн, сургууль, багш бүрт бие даах эрх мэдэл, өвөрмөц арга барил тун бага байсантай холбоотой. Ялангуяа сурах бичиг, хичээлийн явц нь хүмүүжил амьдралтай уялдаа багатай явагддаг, ирээдүйн иргэний эрдэм боловсрол, ёс суртахуун, бие бялдар, ой ухаан, амьдрах аргын талаар эртнээс жигд бэлтгэхийг цогцолбороор авч үзэхгүй явдал багагүй нөлөөлсөн хэрэг. Үүнээс гадна суурь мэдлэг олгохдоо багшийн заах, сурагчийн сонсож судлах болон хичээл давтан бататгах, шалгалт шүүлэг авах, өгөх арга нь гол төлөв цээжлэн тогтоолгох догматик хэлбэрт орсныг тэр бүр ухаардаггүй байжээ. Энэ бүхэн бол сургалтыг муу явуулах гэсэн зориудын сэтгэл дээр биш гагцхүү болж бүтэж байна гэсэн сэтгэлгээн дээр тулгуурлаж ирсэнд хамаг гай нь оршино. Хэрэв эдгээр шалтгааныг бид амьдрал практик дээр нэгэнт ажиглаж авсан юм бол, хэрэв уг байдлыг өөрчилж сургалт хүмүүжлийн ажлыг шинэ шатанд гаргахыг зорьж байгаа юм бол урьдах дутагдал гажуудал бүхнийг арилгах нь хойшлуулшгүй зорилт мөн.²¹

Судалгаанаас үзэхэд, 1941-1989 оны академик, мэдлэгжүүлсэн шинжтэй эх хэлний сургалтын үед сургалт хүмүүжлийн ажлыг сайтар хослуулж ирсэн ч харамсалтай нь, тухайн нийгэм улс төрийн байдлаас шалтгаалан коммунист хүмүүжлийг олгоход л чиглэж байв. 1990 оноос хойшхи эх хэлний сургалт хэдий онол хэрэглээ хосолсон,

¹⁸⁾ Ш.Ичинхорлоо, Боловсролын тухай шинжлэх ухааны удиртгал, улаанбаатар, 2012, 10 тал

¹⁹⁾ Ж.Даваа, Сурган хүмүүжүүлэх зүй, Улаанбаатар, 2012, 125 тал

²⁰⁾ Ч.Базарханд (2002) Хүүхдийг эх хэлд нь сургаж байсан ардын уламжлалаас//, *Монгол судлал, улстөр, эдийн засаг, гүн ухаан, хууль зүй*. Том 18., fasc 1-7 х., Улаанбаатар, 7-р тал

²¹⁾ Ц.Балхаажав, Үүрдийн дурсгал номон хөшөө, II боть, Улаанбаатар, 2004, 107-108 тал

харьцангуй чадварт суурилсан шинжтэй болсон боловч уг хичээлээр олгогддог хүмүүжлийн ажлыг орхигдуулсаар иржээ.

Эх хэл бол эрдэм сурахын оньсон түлхүүр, мэдлэг олох, мэдээлэл хүлээн авах анхдагч эх булаг болох билээ. Тиймээс эх хэлний сургалтаас бүх хичээлийн сургалтын чанар, үр дүн хамаарна гэж хэлэхэд хэтрүүлэл болохгүй. Иймд монгол хэлний хичээлийн үр дүнг дээшлүүлэх, сурагчдад эх хэлийг нь төгс сайн эзэмшүүлэх явдал чухал төдийгүй бас бие хүнийг төлөвшүүлэн хүмүүжүүлэхэд энэ хичээлийн үүрэг боломжийг анхаарахгүй байж болохгүй.²²

Д.Баттогтох “Монгол хэлний хичээлээр юуны өмнө үндэсний хэл бичгээрээ бахархах, эх хэлээ хайрлах үзэл хүмүүжил төлөвшүүлэх ёстой. Эх хэлээ хайрлах нь эх оронч хүмүүжлийн салшгүй хэсэг болно. Хэрэв эх хэлээ хайрлан хүндэтгэх сэтгэл ухаарал хомс байх юм бол эх оронч үзэл бахархал бүрэн төлөвшихгүй. Иймд монгол хэлний хичээлээр хүмүүжүүлэх нэг чухал сэжиг бол сурагчдад эх хэлний тухай мэдээллээр дамжуулан эх оронч хүмүүжил, эх хэлээ хайрлах, хэлийг бүтээсэн ард түмнээрээ бахархах үзэл, хүмүүжил олгох явдал мөн байна...

... Юуны өмнө сурагчдыг нийгмийн зөв боловсон харилцаанд сургах, эх хэлээрээ эвтэй найруулан бичдэг, хэл ярианы соёлтой иргэдийг нийгэмд бэлтгэн төрүүлэх явдал юм. Энэ бол монгол хэлний хичээлийн хүмүүжүүлэх гол үүрэг мөн. Ер нь хэлний соёл, ярих бичих чадварыг эзэмшүүлэхэд монгол хэлний хичээл бүхэлдээ чиглэгдэх ёстой...

... Сурагчдын хэлний мэдрэмж, хэлний ухаарал логик сэтгэлгээг хөгжүүлэх явдал чухал юм. Энэ нь хэлэнд бүтээлч ухамсартай суралцахад төдийгүй эх хэлний хүмүүжилд онцгой нөлөөтэй. Үүнийг монгол хэлний сургалтад зайлшгүй анхаарвал зохино. Хэлний зөв ухаарал, сэтгэлгээг эзэмших нь зөвхөн төрөлх хэлээ ухамсартай, бүтээлч сурахад төдийгүй бас бусад ард түмний хэлийг үзэж судлахад эх хэлтэйгээ харьцуулан ижил төстэй, ялгаатай шинжүүдийг ойлгосноор гадаад хэл сурахад дөхөмтэй болдог байна. Өөрөөр хэлбэл эх хэлний мэдлэг боловсрол гадаад хэл сурах суурь дэвсгэр болно²³... гэсэн нь нарийндаа монгол хэлний хичээлийн зорилго, зорилтыг маш оновчтой тодорхойлсон, нөгөө талаас эх хэлний сургалт хүнийг хүн болгодог гол зэвсэг гэдгийг нотолсон хэрэг.

Аливаа хэл нь тухайн хэлээр харилцагчдын харилцааны хэрэглүүр болохын зэрэгцээ тэдний угсаа, ёс заншил, соёл, түүх, аж төрөх ёсны элдэв тусгал, илэрхийлэл, баримт болж байдаг тул тэр хэлний хичээлийн цар хүрээ нь зөвхөн хэлний бүтэц, хэлзүйн дүрэм төдийгөөр хязгаарлагдах ёсгүй.

Хүүхдийг эхийн цагаан сүүгээр нь амлуулан байж эрүүл чийрэг хүн болгодгийн адил хүүхдийг эх хэлний сургалтаар нь дамжуулж эрдэм боловсролтой, эх оронч сэтгэлгээтэй, өв тэгш хүмүүжилтэй “жинхэнэ” монгол хүн болгоно. Өөрөөр хэлбэл, эх хэлний сургалтын эрхэм зорилго нь хүүхдэд эх оронч сэтгэлгээ суулгах, ёс суртахууны хүмүүжил олгох явдал хэмээн үзэж байна.

Үүний зэрэгцээ, эх хэлний сургалтаар сурагчдад ярих, бичих, унших чадварыг эзэмшүүлнэ. Зөвхөн хэлний хэлбэр бүтэц, хэлзүй дүрэм бус хэл сэтгэхүй, хэл соёл, хэл заншил, хэл түүхийн олон талын уялдаат цогц мэдлэг олгох ёстой. Сурагчдын хэлний мэдрэмж, хэлний ухаарал логик сэтгэлгээг хөгжүүлнэ.

²²⁾ Д.Баттогтох, *Монгол хэлний хичээлийн хүмүүжүүлэх нөлөөний асуудал*, Хичээлийн хүмүүжүүлэх үр нөлөөг дээшлүүлэх зарим асуудал, Улаанбаатар, 1988, 9-17

²³⁾ Мөн, 9-17

Сургалтын зорилго бол сургах, сурах үйл ажиллагааны эцэст ямар үр дүн гарахыг урьдчилан томъёолох явдал²⁴ бөгөөд зорилгоо оновчтой зөв тодорхойлоогүй цагт сургалтын чанар хийгээд үр дүн ярих нь эрт бөлгөө.

Захиргаадан сургах барилыг гэгэээрүүлэн сургах аргад шилжүүлж, сургалтыг ардчилах, либеральчлах шаардлагатай байна.²⁵

²⁴⁾ Ш.Ичинхорлоо, Боловсролын тухай шинжлэх ухааны удиртгал, Улаанбаатар, 2012, 10-р тал

²⁵⁾ Л.Түдэв, Боловсроогүй боловсрол, Улаанбаатар, 1990, 13-р тал